



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.12.06 № 03/2256

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102627 дугаартай “Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)” нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Багц: 3 Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний багаж тоног төхөөрөмж 1. Ларингоскоп Насанд хүрэгсэд болон хүүхэд тусдаа багц байх гэдэг нь насанд хүрэгчдэд зориулсан багц 1ш, хүүхдэд зориулсан багц 1 ш нийтдээ 2 ш гэж ойлгох уу? эсвэл нэг багц дотроо насанд хүрэгч болон хүүхдийн багц хамтдаа ороод нийт 2 ш гэж ойлгох уу? Тодруулж өгнө үү? Мөн тус аппаратын үзүүлэлт дээр цэнэглэдэг зай, 3.5 вольтын цэнэглэдэг батарейтай -Дагалдах хэрэгсэл: Батарей, батарей цэнэглэгч, ларингоскопын хошуу гэж шаарджээ. Цэнэглэгчтэй ийм төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн ханш нь 3,500,000 төгрөг байдаг Цэнэглэгддэг батарейгүй загвар нь 200,000-350,000 төгрөг байдаг. Иймд шаардсан үзүүлэлтийг өөрчлөх эсвэл нэгж үнийг өөрчлөх эсэх дээр тодруулга өгнө үү.</p>	<p>Багц3-ын яаралтай тусламж, эрчимт эмчилгээний багаж тоног төхөөрөмжийн: Ларингоскопийн хувьд насанд хүрэгчдэд болон хүүхдийн багц нь тус тусдаа 1 ширхэг байх ба цэнэглэдэг байх шаардлагатай.</p>
2	<p>Багц: 3 Хурууны пульсоксиметр Нярай болон том хүнд зориулагдсан байх гэсэн байна. Бусад үзүүлэлтийг харахаар энэ төрлийн пульсоксиметр нь хүүхэд болон том хүнд зориулагдсан бөгөөд нярайд ашиглагдах боломжгүй. Иймд нярай гэдгийг хасаж өгнө үү. (Жич: энэ багцын 14 дэх бүтээгдэхүүн дээр нярайн пульсоксиметрийг тусад нь заасан байгаа болно.)</p>	<p>Хурууны пульсоксиметр нь том хүнд ашиглагдах зориулалттай байна.</p>
3	<p>Багц:3 Тарианы автомат шахуурга Энэ бүтээгдэхүүний техник үзүүлэлт нь тарианы автомат шахуургын үзүүлэлт биш бөгөөд дуслын</p>	<p>Багц: 3-ын 8 дахь бүтээгдэхүүн болох Тарианы автомат шахуургын техник үзүүлэлт нь 9</p>

	автомат шахуургын үзүүлэлт байна. тус багцын 9 дэх бүтээгдэхүүн болох дуслын автомат шахуургын үзүүлэлт нь тус багцын 8 дахь бүтээгдэхүүн болох тарианы автомат шахуургын үзүүлэлт байна. Тэгэхээр энэ 2 үзүүлэлт нь хоорондоо солигдсон гэж харагдаж байгаа тул тодруулж өгнө үү.	дэх бүтээгдэхүүн болох дуслын автомат шахуургын техник үзүүлэлттэй солигдож техникийн тодорхойлолтод орсон байх тул тендерт оролцогч та бүхэн тус багцын 8, 9 дэх бүтээгдэхүүний техникийн үзүүлэлтийг хооронд сольсон гэдгийг анхаарч тендер ирүүлнэ үү.
4	Багц:3 Өвчтөний хяналтын монитор NIBP: - Хэмжилтийн хязгаар: Том хүн: SYS 25-290 mmHg, DIA 10-250 mmHg, MEAN 15-260 mmHg байх - Нярай: SYS 25-140 mmHg, DIA 10-115 mmHg, MEAN 15-125 mmHg байх гэж заасан байна. Энэ үзүүлэлт нь үйлдвэрлэгчээс хамаарч өөр өөр байдаг бөгөөд заасан дээд доод хэмжээний хоорондох зөрүү өндөр байх тусам илүү ач холбогдолтой. Уг үзүүлэлт нь зөвхөн Хятад улсын EDAN үйлдвэрлэгчийн үзүүлэлт бөгөөд бусад үйлдвэрлэгчийн өрсөлдөх боломжийг хязгаарлаж байгаа тул дүйцэхүйц бүтээгдэхүүнээр орж болох боломжийг хангаж, үзүүлэлтийг тодруулж өгнө үү.	Өвчтөний хяналтын мониторийн NIBP хэмжилтийн хязгаар : Том хүн: SYS 25-290 mmHg, DIA 10-250 mmHg, MEAN 15-260 mmHg, Нярай: SYS 25-140 mmHg, DIA 10-115 mmHg, MEAN 15-125 mmHg дээд доод хэмжилтийн хоорондох зөрүү боломжит хэмжээ ба дүйцүүлэн оролцоно уу.
5	Багц: 3 Автомат даралтын аппарат Уг аппаратын төсвийн нэгж үнэ 700,000 төгрөг гэж заасан байна. Гэтэл доор дурьдсан үзүүлэлт нь Contec үйлдвэрийн 07A загварын суурин даралтын аппаратын үзүүлэлтийг тэр чигээр нь хуулбарлан оруулжээ. Уг загварын зах зээлийн үнэ нь 4,500,000-5,000,000 төгрөгийн хооронд байдаг. Иймд шаардсан үзүүлэлтийг өөрчлөх эсвэл нэгж үнийг өөрчлөх эсэх дээр тодруулга өгнө үү? Доор үзүүлэлтийг орууллаа. Omron эсхүл түүнтэй дүйцэхүйц байна. Параметрууд: Хэмжилтийн арга: осциллометр Хэмжилтийн горим: дээд гар Хүрээ: 0 ~ 297 мм МУБ (0 ~ 39.6 кПа) АД хэмжих хүрээ: Систолын даралт: 4 кПа (30 ммМУБ) ~ 36 кПа (270 ммМУБ) Дундаж даралт: 2.7 кПа (20 ммМУБ) ~ 31.3 кПа (235 ммМУБ) Диастолын даралт: 1.3 кПа (10 ммМУБ) ~ 29.3 кПа (220 ммМУБ) Нарийвчлал: 0.133 кПа (1 ммМУБ) PR хэмжилтийн хүрээ: 40 bpm ~ 240 bpm Нарийвчлал. Статик даралт: ± 3 ммМУБ (± 0.4 кПа) PR нарийвчлал: ± 2 % эсвэл ± 2 цохилт/минут, аль нь их байна Дэлгэцийн горим: өнгөт LCD Цахилгаан хангамж: 100 - 240 V ~ , 50/60 Гц Аюулгүй байдлын ангилал: I анги, BF төрлийн хэрэглээний хэсэг	Автомат даралтын аппаратын нэгж үнийн дүнг өөрчлөх боломжгүй тул тухайн нэгж үнийн дүнд тохирсон болон техник үзүүлэлтэд дүйцэхүйц аппарат байх шаардлагатай байна. Мөн сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн үзүүлэлт, түүний үйлдлийн систем, программ хангамжийн талаар, зөвхөн тухайн тоног төхөөрөмжид тохирдог дагалдах хэрэгсэл, үйлдвэрлэгчийн тохиргоо зэргээс шалтгаалан манай эрүүл мэндийн төвөөс нарийвчлан гаргах боломжгүй зарим тоног төхөөрөмжийн үзүүлэлтэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дах хэсэгт заасны дагуу “эсхүл түүнтэй дүйцэхүйц” гэсэн тодотголыг тусган илгээсэн болно
6	Багц: 6 Суурин рентген аппарат дээр: Өмнө нь зарлахдаа Зураг авалт 50 KW (500mA, 100KV, 01S) бөгөөд бусад үзүүлэлт нь 50KW-тай таарсан хүчин чадалтай байсан. Гэтэл техник тодорхойлолтыг шинэчлэн зарлахдаа Зураг авалт 80 KW (500mA, 100KV, 01S) болгож өөрчилсөн боловч бусад үзүүлэлт нь 50 KW (500mA, 100KV, 01S) энэ үзүүлэлтэд таарсан хэвээр зарлажээ. Тиймээс уг үзүүлэлтүүд хоорондоо таарч ажиллахгүй 50 эсвэл 80 KW гэдгийг тодруулж өгнө үү. Хэрэв 80KW бол уг үзүүлэлтэд таарах бусад үзүүлэлтээ шинэчилнэ үү.	Суурин рентген төхөөрөмжийн зураг авалт 80kW(500mA,100KV,0.1S) байх ба зөөврийн рентген аппаратын: сцинтиллятор: шууд орд CsI:TI, идэвхтэй талбай: 433.7 x 354.8 мм, пикселийн массив: 2816 x 2304,пикселийн давтамж: 154 μm энэ детекторын үзүүлэлттэй дүйцүүлэх боломжтой.

	<p>2. Зөөврийн рентген аппарат дээр: FPD  Сцинтилятор: Шууд орд Csl: T1  Идэвхтэй талбай: 433.7x354.8 мм  Пикселийн массив: 2816x2304  Пикселийн давтамж: 154um  гэж заасан нь Хятад улсын Care Ray үйлдвэрийн детекторын үзүүлэлтийг шууд заасан байна. Энэ нь бусад үйлдвэрлэгчийн илүү чанартай бүтээгдэхүүнээр ороход хүндрэлтэй болгож байгаа тул эдгээр үзүүлэлттэй дүйцүүлэн оролцож болох талаар тодруулж, дэлгэрэнгүй тайлбар өгнө үү.</p>	
7	<p>Багц: 6 Суурин рентген аппарат төхөөрөмжийн техник үзүүлэлтүүд болон нарийвчилсан функц болох Virtual Dual- Engergy subtraction, Imaga Stitching BMD (Optional) AI (Optional) үзүүлэлтүүд нь хороондоо зөрчилдөн бүрэн хангахгүй үйлдвэрлэгч байхгүй байгаа тул BDM (Optional) AI (Optional) функцүүдийн заавал санал болгох шаардлага эсэх талаар тодруулж өгнө үү.</p>	<p>Суурин рентген төхөөрөмжид нарийвчилсан функц болох BMF(Optional), AI(Optional) үзүүлэлтүүд байх шаардлагагүй болно.</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	<p>ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1  Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:  Огноо: 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр  Цаг: 10 цаг 00 минут гэснийг;</p>	<p>ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1  Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:  Огноо: 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр  Цаг: 10 цаг 00 минут гэж;</p>
2	<p>ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.2  Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.  Огноо: 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдөр  Цаг: 10 цаг 30 минут гэснийг;</p>	<p>ТББ-ын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.2  Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.  Огноо: 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр  Цаг: 10 цаг 30 минут гэж.</p>

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.